



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/379

Хэрлэн сум

**Сонгон шалгаруулалтын  
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 6.2.3 дахь заалтын дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын “Гэр хорооллын айл өрхийг инженерийн шугам сүлжээнд холбох ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

дарга:

Н.Үнэнбат

Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн

дарга:

Б.Оюундарь

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

А.Нандин-Эрдэнэ

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

Д.Бат-Эрдэнэ

Хэрлэн сумын Засаг даргын орлогч

Б.Одгэрэл

Хэрлэн сумын газрын даамал

2.Хэнтий аймгийн Хэрлэн сумын “Гэр хорооллын айл өрхийг инженерийн шугам сүлжээнд холбох ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах арга хэмжээг журмын дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг Ажлын хэсгийн дарга (Н.Үнэнбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ